





Манай улс нефтийн бүтээгдэхүүнийхээ хэрэглээг 100.0 хувь импортоор хангаж байна. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад автобензиний импортын үнийн дүн 31.7 сая ам.долл, суудлын автомашины импортын биет хэмжээ 4443 ш, үнийн дүн 18.4 сая ам.долл, цахилгаан эрчим хүчний импортын биет хэмжээ 60.4 сая квт.цаг, үнийн дүн 3.4 сая ам.доллараар тус тус өсч, харин автобензиний 10.1 мян.т, гурилын импортын 12.7 мян.т, үнийн дүн нь 7.9 сая ам.доллараар буурчээ (Зураг 7).

Нефтийн бүтээгдэхүүний импорт 2010 оны эхний хагас жилд 350.2 мян.т буюу 279.3 сая ам.долл болж, нийт импортын үнийн дүнгийн 20.6 хувийг эзэлж байгаагийн зэрэгцээ өмнөх сарынхтай харьцуулахад 76.2 мян.т буюу 27.8 хувиар өссөн байна.

Манай улс хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тосыг 100 хувь импортоор авч байна. 2010 оны эхний хагас жилд цагаан будааны 83.7 хувийг БНХАУ-аас, элсэн чихрийн 61.2 хувийг Тайланд улсаас, 11.8 хувийг Их Британиас, 7.5 хувийг БНХАУ-аас импортолсон байна. Харин ургамлын тосны 93.9 хувь, гурилын 87.8 хувийг ОХУ-аас импортолжээ.

Элсэн чихрийн импорт 2010 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеийнхээс 7.5 мян.тонноор нэмэгдэж, харин цагаан будааных 3.8 мян.тонноор буурлаа.

Импортолсон барааны 89.8 хувийг валютын төлбөртэй худалдаа, 4.9 хувийг тусламжийн бараа, 4.2 хувийг гадаадын хөрөнгө оруулалтын бараа, 0.6 хувийг зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа, 0.3 хувийг бараа солилцооны бараа, 0.1 хувийг гадаадын захиалагчийн материалаар үйлдвэрлэсэн эд зүйлс, үлдсэн 0.1 хувийг бусад бараа эзэлж байна.

Зарим барааны импорт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, мян ам.долл

